



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
**ХУРААНГУЙ ТАЙЛАН**

**АУДИТЫН СЭДЭВ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН  
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Аудит хийсэн  
үндэслэл, бүрэн  
эрх**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**ТӨСӨВТ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХДЭЭ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТААР 5,309.9 САЯ ТӨГРӨГИЙН 23 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ШИНЭЭР  
НЭМЖ БАТАЛСАН БАЙНА**

Аудитын тайланг Дархан-Уул аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тус тус хүргүүлсэн.

**Дархан-Уул аймаг**

**2023 оны 04 дүгээр сар**

**Аудитын харилцан хамаарал**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан.

**Аудитын зорилго, зорилтууд**

Дархан-Уул аймгийн 2022 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлж, зарлагыг үр дүнтэй зарцуулсан эсэхэд дүгнэлт гарган, аймгийн удирдлагад танилцуулах зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
2. Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх;
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитыг Дархан-Уул аймгийн орон нутгийн төсөв, ТЭЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг орон нутгийн төсвийн 35, тусгай зориулалтын 60 байгууллага, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, замын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2022 оны санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

**Ерөнхий мэдээлэл**

Дархан-Уул аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагыг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор 54,244.8 сая төгрөг баталж, төсвийн зохицуулалтаар 17,432.4 сая төгрөгөөр нэмж, төсвийн тодотголоор 2,834.2 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд төсвийн нийт орлогын гүйцэтгэл 101.6 хувиар, зарлагын гүйцэтгэл 84.1 хувьтай гарсан байна.

## БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТААР ОРЛОГО, ЗАРЛАГЫГ 1,780.8 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор төсвийн орлого, зарлагыг 54,244.8 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, аймгийн ИТХ-ын тогтоолоор төсвийн орлогод 2 удаа өөрчлөлт оруулжээ.

### Хүснэгт 1. Төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Анх баталсан төсөв /2021.12.03/	Зохицуулалт /2022.03.21/	Тодотгол /2022.06.23/
	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>35,248.6</b>	<b>43,302.0</b>	<b>45,082.8</b>	<b>44,596.1</b>
1	Татварын орлого	30,619.2	33,903.0	35,634.8	35,123.1
2	Татварын бус орлого	4,629.4	9,399.0	9,448.0	9,473.0

Төсвийн тодотголыг өмнөх оны гүйцэтгэлээс 9,347.5 сая төгрөгөөр өсгөж төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-т заасны дагуу аймгийн төсөвт төвлөрүүлэх ААНОАТ-ын орлогыг 5,150.0 сая, “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн хүүгийн орлогыг 6,005.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой.

### Хүснэгт 2. ТЕЗ-ийн 2022 оны төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө /сая төгрөг/

Үзүүлэлт	Анх батлагдсан (2021.12.03)	Төсвийн зохицуулалт (2022.03.21)	Тодотгол (2022.06.23)	Зөрүү	
				Төсвийн зохицуулалт	Тодотгол
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>54,244.8</b>	<b>71,677.2</b>	<b>68,843.0</b>	<b>17,432.4</b>	<b>(2,834.2)</b>
А. УРСГАЛ ЗАРДАЛ	46,714.5	39,567.8	38,001.1	(7,146.7)	(1,566.7)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,725.7	31,199.3	29,931.8	24,473.6	(1,267.5)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	804.6	910.1	910.1	105.5	-

Аймгийн ИТХ-ын тогтоолоор “Зулзагын гол дахь хүүхдийн амралтын газар”-ын засварт 350.0 сая, “Нийтийн орон сууцны дээвэр, инженерийн шугам сүлжээ”-ний засварт 450.0 сая, нийт 800.0 сая төгрөгийн засварын зардлыг орон нутгийн 2022 оны төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийн дагуу төлөвлөөгүй байна

Төсвийн зохицуулалтаар орлого, зарлагыг 1,780.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, төсвийн тодотголоор шалтгаангүйгээр 543.7 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 23 шинэ төсөл, арга хэмжээний 5,309.9 сая төгрөгийг нэмж баталсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2<sup>1</sup>, 23 дугаар зүйлийн 23.8<sup>2</sup>, 23.8.1<sup>3</sup>, 27 дугаар зүйлийн 27.1.2<sup>4</sup>, 42 дугаар зүйлийн 42.2<sup>5</sup>, 42.2.1а<sup>6</sup>, 42.2.1б<sup>7</sup>, 42.4<sup>8</sup>, 42.7<sup>9</sup>, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2.1<sup>10</sup>-д заасантай тус тус нийцэхгүй байна.

<sup>1</sup> жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх

<sup>2</sup> Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ

<sup>3</sup> 23.8.1.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар;

<sup>4</sup> макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх

<sup>5</sup> төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно

<sup>6</sup> өөрийн төсийн багцад хамаарах хөтөлбөр хооронд

<sup>7</sup> түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд

<sup>8</sup> Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна

<sup>9</sup> Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

<sup>10</sup> Төсвийн захирагч дор дурдсан нөхцөлд батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж болно:

## БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 1.6 ХУВИАР ДАВСАН БАЙНА

Дархан-Уул аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн суурь орлого 45,703.3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1,107.2 сая төгрөгөөр давж, өмнөх оноос 10,454.7 сая төгрөгөөр өссөн байна.

### Хүснэгт 4. Төсвийн орлогын гүйцэтгэл (сая төгрөг)

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 он				Өмнөх оны зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
Татварын орлого	30,619.2	35,123.1	41,001.0	5,877.9	116.7	10,381.8
Татварын бус орлого	4,629.4	9,473.0	4,702.3	(4,770.7)	49.6	72.9
<b>Нийт дүн</b>	<b>35,248.6</b>	<b>44,596.1</b>	<b>45,703.3</b>	<b>1,107.2</b>	<b>102.5</b>	<b>10,454.7</b>

Аймгийн татварын орлого төлөвлөснөөс 16.7 хувиар буюу 5,877.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Цалингийн хэмжээ өмнөх оноос 13.0 хувиар өссөнөөр цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 5,077.0 сая, ААНОАТ-ын орлого 5,644.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь татварын орлого өмнөх оноос 10,381.8 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ. Харин татварын бус орлого төлөвлөснөөс 49.6 хувиар буюу 4,770.7 сая төгрөгөөр буурсан нь “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн хүүгийн 6,005.5 сая төгрөгийн орлого орж ирээгүйтэй холбоотой бөгөөд тус орлогыг “Дархан Ус суваг” ХК-аас авах авлагаар тусгажээ.

### Аймгийн төсвийн нийт орлого биелсэн боловч зээлийн хүүгийн орлого 6,005.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн татварын орлого 5,082.3 сая төгрөгөөр давж, төсвийн орлого 14,115.9 сая төгрөгт хүрч гүйцэтгэл 101.6 хувиар биелсэн ч татварын бус орлого 4,859.2 сая төгрөгөөр тасарчээ.

### Хүснэгт 5. Аймгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Өмнөх оноос	Төлөв-с
Татварын орлого	22,977.6	5,690.0	10,772.3	(12,205.3)	5,082.3
Татварын бус орлого	2,810.4	8,202.8	3,343.6	533.2	(4,859.2)
<b>Нийт орлого</b>	<b>25,788.0</b>	<b>13,892.8</b>	<b>14,115.9</b>	<b>(11,672.1)</b>	<b>223.1</b>

ААНОАТ-ын орлогоор 444.0 сая төгрөг төвлөрч, 8.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан тул орлогын биелэлт хангалтгүй нөхцөл байдлыг харгалзаж Сангийн яамнаас оны эцэст 2023 оны орлогоос 5,200.0 сая төгрөг урьдчилан олгосон байна. Энэ нь дараагийн төсвийн жилд орлого бүрэн төвлөрөхгүй байх, төлөвлөсөн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах эрсдэлтэй.

Сумдад төвлөрөх орлогын нэр төрөл нэмэгдсэнээр орлого нийт дүнгээр 884.2 сая төгрөгөөр буюу 102.9 хувиар давсан байна.

### Хүснэгт 6. Сумдын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
					Өмнөх оноос	Төлөв-с
1	Дархан сум	7,431.3	24,159.2	24,748.9	17,317.6	589.7
2	Шарын гол сум	474.3	1,818.5	1,818.0	1,343.7	(0.5)
3	Орхон сум	1,269.3	406.3	523.5	(745.8)	117.2
4	Хонгор сум	296.7	4,319.3	4,497.1	4,200.4	177.8
<b>Нийт орлого</b>		<b>9,471.6</b>	<b>30,703.3</b>	<b>31,587.5</b>	<b>22,115.9</b>	<b>884.2</b>

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн нэмэлт өөрчлөлтөөр үл хөдлөх албан татвар, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварыг сумдад төвлөрүүлэх болсноор төсвийн орлого өмнөх оноос 22,115.9 сая, батлагдсан төсвөөс 884.2 сая төгрөгөөр давж биелжээ.

### БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2020 оны 02/08 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 267 зорилт, 318 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас тайлант онд 66 зорилт, 300 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, нийт 948.8 сая төгрөг баталснаас урсгал зардалд 649.2 сая, хөрөнгийн зардалд 224.8 сая, нийт 874.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### Хүснэгт 7. Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	2021 он гүйцэтгэл	2022 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>73,805.4</b>	<b>68,843.0</b>	<b>57,890.1</b>	<b>84.1</b>	<b>(10,952.9)</b>
А. УРСГАЛ ЗАРДАЛ	62,602.4	38,001.1	34,496.1	90.8	(3,505.0)
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,710.6	29,931.8	22,845.6	76.3	(7,086.2)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	492.4	910.1	548.4	60.3	(361.7)

Орон нутгийн төсвийн байгууллагууд урсгал зардлыг 9.2 хувиар буюу 3,505.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд санхүүжилтийг тухай бүр эрэмбэлэн гүйцэтгэлээр хянах, бараа үйлчилгээний бусад зардлыг нийт төсвийг 10-аас багагүй хувиар хэмнэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн 2022 оны төсвийн суурь орлого, зарлагын дүнд “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний зээл, зээлийн хүүгийн төлбөрт 6,005.5 сая төгрөгөөр тооцсоныг аймгийн төсвийн ерөнхий орлогоос 2 удаа нийт 1,883.6 сая төгрөгийг суутган тооцож, оны эцэст урьдчилж орсон 5,200.2 сая төгрөгийн ААНОАТ-ын орлогоос 4,122.0 сая төгрөгийг төлжээ. Цаашид хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн алдангиас шалтгаалж, аймгийн төсөвт хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

#### Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн байгууллагуудад тайлант онд нэмэлт санхүүжилтээр 3,431.1 сая төгрөг төвлөрсөн нь өнгөрсөн оноос 104.7 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл нь Засгийн газраас иргэдийн орон нутагт ажиллах, шилжин суурьших ажлыг дэмжих хөтөлбөрт зарцуулахаар ЗГХЭГ-аас шилжүүлсэн 200.0 сая, Сангийн яамнаас цэцэрлэг, сургуулиудын урсгал засварын санхүүжилтээс 181.9 сая, Дархан-Улаанбаатар хоорондын замын ажлын нөхөн төлбөр 170.5 сая, Шарын голын үйлдвэрийн зураг төслийн санхүүжилт 76.5 сая, БОАЖЯ-аас орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн үлдэгдэл 18.5 сая, урьд оны үлдэгдлээс зарцуулах 25.4 сая төгрөгийн зардлыг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

#### Төсвийн жилийн дундуур хөрөнгийн зардлыг 12,603.4 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс хөрөнгийн зардал 83.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, их засварын хөрөнгө оруулалтаар 21,189.3 сая төгрөгийн 172 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан нь өмнөх оноос 9,274.3 сая төгрөгөөр өсжээ. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 17,789.8 сая төгрөгийн 149 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 83.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Хүснэгт 10. ОНХО-ын батлагдсан төлөвлөгөө, төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

Аймаг, сумын нэр	ОНХО		Замын сан		Их засвар	
	TAX-ний тоо	Мөнгөн дүн	TAX-ний тоо	Мөнгөн дүн	TAX-ний тоо	Мөнгөн дүн
Аймаг	140	17,023.6	6	1,910.2	7	1,170.3
Дархан сум	14	1,025.2	-	-	-	-
Хонгор сум	5	60.0	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>159</b>	<b>18,108.8</b>	<b>6</b>	<b>1,910.2</b>	<b>7</b>	<b>1,170.3</b>

Тайлант хугацаанд нийт 3,736.6 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл нь дараа онд дамжин хэрэгжих 28 төсөл арга хэмжээний 3,607.1 сая, гүйцэтгэгчид олгох чанарын баталгаат хугацааны барьцаа 271.0 сая, тендерийн хэмнэлт 200.8 сая, тендер зохион байгуулалт зэргээс шалтгаалжээ.

### **Батлагдсан журмын дагуу сумдын ХХС-аас нийт 548.4 сая төгрөгийн зээл олгож, гүйцэтгэл 60.2 хувьтай байна**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” хэрэгжиж эхэлснээр ААНБ, хоршоодод зээл олгох болсонтой холбоотойгоор 361.7 сая төгрөгийн зээл олгогдоогүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/243 дугаар тушаалаар дээрх журамд өөрчлөлт оруулж, иргэдэд зээл олгох болсноор нийт 548.4 сая төгрөгийн зээл олгожээ.

Сумдын ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 59 иргэн, ААНБ-ын 303.3 сая төгрөг болж өмнөх оноос 21.0 сая төгрөгөөр өссөн бол 53 зээлдэгчийн 166.6 сая төгрөгийг төлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

### **ДҮГНЭЛТ:**

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлээгүйгээс төсөвт зохицуулалт хийхдээ орлого, зарлагыг 1,780.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.
2. Төсөвт зохицуулалт хийхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,309.9 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээ шинээр нэмж баталсан байна.
3. Төсвийн тодотголоор цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг 543.7 сая төгрөгөөр тооцоо судалгаагүйгээр бууруулсан байна.
4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засварын жагсаалтад 800.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг чиглэл, удирдамжийн дагуу төлөвлөөгүй байна.
5. Төсвийн тодотголоор боловсрол, эрүүл мэнд, соёл, Политехник коллежийн байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 514.7 сая, урсгал засварын зардлыг 182.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн ч төсвийн гүйцэтгэлээр нийт 1,038.1 сая төгрөгийн зардал хэмнэсэн байна.
6. ААНОАТ-ын урьдчилж орсон 5,200.2 сая төгрөгийн орлогоос “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл”-ийн зээлийн төлбөрт 4,122.0 сая төгрөг төлсөн байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Азжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарт зөвлөх нь:

1. Төсвийн зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг баримталж, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх
2. Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх
3. Төсвийн зохицуулалт хийхдээ төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх
4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх их засварын зардлыг төлөвлөхдөө Сангийн яамны чиглэл, удирдамжийг баримтлах